

**ИМПОРТЫН ЗАРИМ БАРААНЫ  
ГААЛИЙН ТАТВАРЫН ХУВЬ, ХЭМЖЭЭ  
/НЭН ТААЛАМЖТАЙ ТАРИФ/**

*УИХ-ын 1999 оны 27 дугаар тогтоол.*

- Ихэнх импортын барааны гаалийн нэн тааламжтай тариф – **5%**;
- Цэвэр үүлдрийн үржлийн амьд мал, амьтад, зарим мэдээллийн технологийн хэрэгсэл 84.71, 8473.30, 85.41, 85.42, эмнэлэгийн зарим багаж хэрэгсэл – **0%**;
- Барилгын хуванцар хаалга, цонх – **6.5%**;
- Блокон хавтан, сликат тоосго, хонины ноосон ээрмэл, эсгий зэрэг – **10%**;
- Мах, шувууны өндөг, зөгийн бал, цөцгий, цөцгийн тос, сүү, цагаан идээ, зайрмаг, тараг, йогурт, хүнсний ногоо, гурил /боомт, улирлаар мөн ялгаатай/, коньяк, виски, ром, джин – **15%**;
- Дарс, адуу үхрийн мах, цемент, бөөрөнхий байцаа, шар лууван, манжин, өргөст хэмх, төмс, модон хаалга, сурталчилгааны хэвлэмэл материал, каталог, ноос, ноолууран, оёмол, сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүнүүд, тоосго зэрэг зарим барилгын материалууд, модон тавилга, хамрын тамхи – **20%**;
- Шар айраг – **25%**;
- Тамхи /Янжуур үйлдвэрлэх зориулалттай тамхинаас бусад/ – **30%**;
- Спиртлэг бусад ундаа – **35%**;
- Цагаан архи, ликёр, кордиал – **40%**;

**ЭКСПОРТЫН БАРААНЫ  
ГААЛИЙН ТАТВАРЫН ХУВЬ, ХЭМЖЭЭ**

*Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай 1996 оны хууль*

Код	Барааны нэр	Хэмжих нэгж	Гаалийн татварын хэмжээ /төгрөг/
44.01 44.03	<u>Бөөрөнхий мод, гуалин</u>	<u>шоо метр</u>	150000
44.03 44.06	<u>Дүнг</u>	<u>шоо метр</u>	150000
44.07 44.09	<u>Зүсмэл материал</u>	<u>шоо метр</u>	150000

**ТУСГАЙ ТАТВАР**

*ЗГ-ын 2000 оны 18 дугаар тогтоол*

4103.10.00, 4301.00.12 кодоод хамрагдах ямаа, ишигний боловсруулаагүй арьсны ширхэг тутамд 1500 төгрөгийн тусгай татвар ногдуулна.

Танд лавлах зүйл байна уу!



**1800-1281**

Гааль сонсож байна



Талархал



Гомдол



Асуулг



Санал

**ГААЛИЙН ЛАВЛАХ УТАС**

Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар үйлчлүүлэгч иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санал, хүсэлт, гомдол, мэдээллийг хүлээн авах, гаалийн хууль тогтоомж, заавар, журам, гаалийн үйлчилгээний талаар мэдээ, мэдээллээр хангах, сан бүрдүүлэх зорилгоор “Гаалийн лавлах-1281” нээлттэй утас ажиллуулж байна.

Гаалийн байгууллагын үйл ажиллагааны талаархи иргэд, байгууллагын асуултуудыг нэгтгэн, дүн шинжилгээ хийж, дүгнэлт гарган мэдээлэл, гомдол саналын мөрөөр шаардлагатай арга хэмжээ авах, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, мэдээлэл, зөвлөлтөө өгөх, сурталчилгаа хийх болон гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.



Хаяг:  
Сүхбаатар дүүрэг, “Их тойруу-81/1”,  
Улаанбаатар-14193, Монгол Улс  
Утас: (976-11) - 350049  
Факс: (976-11) - 350048  
E-mail: info@customs.mn  
Интернет: http://www.customs.gov.mn



МОНГОЛ УЛСЫН  
ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

**ГААЛИЙН ТАРИФ,  
ГАРАЛ ҮҮСЭЛ**



УЛААНБААТАР ХОТ  
2019 ОН

**ГААЛИЙН ТАРИФ, ТАРИФЫН ТӨРЛҮҮД**

“**Гаалийн тариф**” гэж гаалийн татварын хувь, хэмжээг хэлнэ. Импортын гаалийн тариф нь дараах 3 төрөлтэй. Үүнд:

- Гаалийн ердийн тариф;
- Гаалийн нэн тааламжтай тариф;
- Гаалийн хөнгөлөлттэй тариф;

“**Гаалийн ердийн тариф**” нь гаалийн нэн тааламжтай тарифаас хоёр дахин их байна. Тус тарифын төрлийг гаалийн нэн тааламжтай тариф хэрэглэх улсын **жагсаалтад багтаагүй** улсын гарал үүсэлтэй, эсхүл импортын барааны **гарал үүслийг нотлох бичиг баримтгүй** бараанд хэрэглэнэ.

“**Гаалийн нэн тааламжтай тариф**”-ыг 1999 оны 27 дугаар тогтоолоор\*\* баталсан. Тус тарифын төрлийг гаалийн нэн тааламжтай тариф хэрэглэх улсын **жагсаалтад багтсан** улсын гарал үүсэлтэй бөгөөд **гарал үүслийг нотлох бичиг баримттай** бараанд хэрэглэнэ.

\*\*Холбоос: <http://legalinfo.mn/law/details/6093>

“**Гаалийн хөнгөлөлттэй тариф**”-ыг Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол улс, Япон улс хоорондын хэлэлцээрийн\*\* дагуу хэрэглэнэ. Тус хэлэлцээрийн 2 дугаар хавсралтаар хөнгөлөлттэй тарифын хэмжээг баталсан.

\*\*Холбоос: [http://customs.gov.mn/Монгол\\_улс,\\_Япон\\_улстай\\_байгуулсан\\_ЭЗТХэлэлцээр/](http://customs.gov.mn/Монгол_улс,_Япон_улстай_байгуулсан_ЭЗТХэлэлцээр/)

**ИМПОРТЫН БАРААНЫ ГАРАЛ ҮҮСЭЛ, ГАРАЛ ҮҮСЛИЙН ҮЛС**

“**Гарал үүсэл**” гэдэг нь барааг үйлдвэрлэсэн газрыг хэлэх бөгөөд барааг үйлдвэрлэсэн улсыг тухайн импортын барааны гарал үүслийн улс гэж үзнэ.

Монголын гаалийн байгууллага ДХБ-ын Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр, /ГАТТ, **Гарал үүслийн дүрмийн хэлэлцээр**/ зэрэг гааль, гадаад худалдаатай холбоотой Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенцийн хэрэгжилтийг ханган ажилладаг.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд “Бараанд нэн тааламжтай тариф хэрэглэх болон эдийн засаг, худалдааны бодлого хэрэгжүүлэх зорилгоор Барааны гарал үүслийн дүрмийг Засгийн газар батална.” гэж заасны дагуу **Засгийн газрын 2016 оны 209 дүгээр тогтоолоор “Импортын барааны гарал үүслийн дүрэм”**-ийг шинэчлэн баталсан.

**Засгийн газрын 2016 оны 209 дүгээр тогтоолын:**



**Хавсралт 1-ээр** “Импортын барааны гарал үүслийн дүрэм”-ийг;

**Хавсралт 2-оор** “Гаалийн нэн тааламжтай тариф хэрэглэх улсын жагсаалт”-ыг;

**Хавсралт 3-аар** “Гаалийн хөнгөлөлттэй тариф хэрэглэх улсын жагсаалт”-ыг тус тус шинэчлэн баталсан.

**ГАРАЛ ҮҮСЛИЙГ НОТЛОХ БИЧИГ БАРИМТ**

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд “Нэн тааламжтай болон хөнгөлөлттэй тарифт хамрагдахын

тулд мэдүүлэгч нь барааны **гарал үүслийг нотлох баримт бичгийг** гаалийн байгууллагад гаргаж өгнө.” гэж заасан.

**Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль:**

**31.7. Барааны гарал үүслийг нотлох баримт бичиг** нь дараах хэлбэртэй байна:

**31.7.1. барааны гарал үүслийн мэдүүлэг** буюу үйлдвэрлэгч, худалдагч, экспортлогчоос барааны гарал үүслийн талаар тусгасан мэдээлэл бүхий үнийн нэхэмжлэх, тээврийн баримт бичиг;

**31.7.2. барааны гарал үүслийг баталгаажуулсан мэдүүлэг** буюу тухайн улсын эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан гарал үүслийн мэдүүлэг;

**31.7.3. барааны гарал үүслийн гэрчилгээ** буюу барааны гарал үүслийг гэрчилж, тухайн улсын эрх бүхий байгууллагаас тусгай маягтаар баталгаажуулан олгосон гэрчилгээ.

**ГАРАЛ ҮҮСЛИЙГ НОТЛОХ БИЧИГ БАРИМТ ШААРДАХГҮЙ БАЙХ ТОХИОЛДОЛ**

**“Импортын барааны гарал үүслийн дүрэм”**

**Засгийн газрын 2016 оны 209 дүгээр тогтоол:**

**4.1. Гарал үүслийг нотлох баримт бичгийг дараах тохиолдолд шаардахгүй:**

**4.1.1.** гаалийн нийт үнийн дүн, тоо хэмжээ нь хууль тогтоомжид заасны дагуу гаалийн болон бусад татвараас чөлөөлөгдөх хэмжээнээс хэтрээгүй зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлс болон улс хоорондын шуудан илгээмжийн бараа;

**4.1.2.** гаалийн үнийн нийт дүн нь 1500 ам.доллараас хэтрээгүй, арилжааны шинж чанартай бараа;

**4.1.3.** түр хугацаагаар оруулахыг зөвшөөрсөн бараа;

**4.1.4.** гаалийн дамжуулан өнгөрүүлэх горимоор тээвэрлэж байгаа бараа;

**4.1.5.** хоёр талт буюу олон талт хэлэлцээрт заасан нөхцлийн дагуу тухайн барааны хувьд бараа нийлүүлэгч улс гарал үүслийн нотлох баримт гаргаж өгөх шаардлагагүй бараа.

<b>“Дүрэм, жагсаалт шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 209 дүгээр тогтоол</b>		
<b>Хавсралт 1.</b> <b>ИМПОРТЫН БАРААНЫ ГАРАЛ ҮҮСЛИЙН ДҮРЭМ</b>	<b>Хавсралт 2.</b> <b>ГААЛИЙН НЭН ТААЛАМЖТАЙ ТАРИФ ХЭРЭГЛЭХ УЛСЫН ЖАГСААЛТ</b>	<b>Хавсралт 3.</b> <b>ГААЛИЙН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ТАРИФ ХЭРЭГЛЭХ УЛСЫН ЖАГСААЛТ</b>
	Дэлхийн Худалдааны байгууллагын гишүүн улс ✓ Бүгд Найрамдах Беларусь Улс	✓ Япон Улс

